




# ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

## ӨРХИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ 2017 ОНЫ ТАНИЛЦУУЛГА



## **ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

Монгол Улс, Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг, Бага тойруу

Засгийн газрын III байр

Утас: (976-11-326414)

Факс: (976-11-324518)

Цахим хуудас: [www.nso.mn](http://www.nso.mn)

И-мэйл: [information@nso.mn](mailto:information@nso.mn)

Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргав.

Улаанбаатар хот, Монгол Улс, 2018 он

## АГУУЛГА

I.	УДИРТГАЛ.....	5
1.1	Оршил.....	5
1.2	Өрхийн орлого, зарлагыг бүртгэхийн ач холбогдол.....	5
II.	ӨРХ ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ.....	6
2.1	Өрх, хүн амын үндсэн үзүүлэлтүүд.....	6
2.2	Өрхийн сууцны нөхцөл.....	9
III.	ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО.....	13
3.1	Өрхийн сарын нийт орлого.....	13
3.2	Өрхийн сарын дундаж мөнгөн орлого.....	15
IV.	ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА.....	19
4.1	Өрхийн сарын нийт зарлага.....	19
4.2	Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага.....	21
V.	ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН.....	25
5.1	Өрхийн орлого ба өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт.....	25
5.2	Ажил эрхлэлт ба цалингийн орлого.....	26
VI.	ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ.....	28
6.1	Өрхийн хэрэглээний зардал.....	28
VII.	ТЭГШ БУС БАЙДАЛ.....	30
7.1	Орлогын тэгш бус байдал.....	30
7.2	Өрхийн хэрэглээний зардлын тэгш бус байдал.....	31
VIII.	ӨРХИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ БУСАД ОРЛОГЫН НӨЛӨӨ.....	34
8.1	Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өрхийн орлогод үзүүлэх нөлөө.....	34
8.2	Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого.....	35
IX.	ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ.....	38
9.1	Хадгаламж.....	38
9.2	Зээл.....	38

## Зурган мэдээллийн жагсаалт

ЗУРАГ 2.1 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ХУВИАР, 2017 ОН.....	6
ЗУРАГ 2.2 ХҮЙСИЙН ХАРЬЦАА, ХУВИАР, 2016-2017 ОН.....	7
ЗУРАГ 2.3 ХҮЙСИЙН ХАРЬЦАА, НАСНЫ БҮЛГЭЭР, 2017 ОН.....	7
ЗУРАГ 2.4 ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2016-2017 ОН.....	8
ЗУРАГ 2.5 АМ БҮЛИЙН БАЙДАЛ, 2016-2017 ОН.....	8
ЗУРАГ 2.6 СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВИАР, 2016-2017 ОН.....	9
ЗУРАГ 2.7 СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВИАР, СУУРЫШЛААР, 2016-2017 ОН.....	10
ЗУРАГ 2.8 СУУЦНЫ ТӨРӨЛ, ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВИАР, БҮСЭЭР, 2017 ОН.....	10
ЗУРАГ 2.9 ӨРХИЙН МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2017 ОН.....	11
ЗУРАГ 2.10 ЗАРИМ ХҮНСНИЙ БУС БАРААНЫ ЗАРДАЛ, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2017 ОН.....	12
ЗУРАГ 3.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ТӨГРӨГӨӨР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	13
ЗУРАГ 3.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	14
ЗУРАГ 3.3 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, БҮСЭЭР.....	14
ЗУРАГ 3.4 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ОРЛОГЫН ТӨРЛӨӨР, УЛСЫН ДУНДЖААР.....	15
ЗУРАГ 3.5 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, УЛСЫН ДУНДЖААР....	15
ЗУРАГ 3.6 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ОРЛОГЫН ТӨРЛӨӨР, ТӨГРӨГӨӨР, .....	16
ЗУРАГ 3.7 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2017 ОН.....	16
ЗУРАГ 3.8 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ОРЛОГООР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, УЛСЫН ДУНДЖААР .....	17
ЗУРАГ 3.9 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ОРЛОГООР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2017 ОН.....	17
ЗУРАГ 3.10 500'001-700'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ОРЛОГОТой ӨРХИЙН ДУНДАЖ ОРЛОГО, УЛСЫН ДУНДЖААР, 2017 ОН.....	18
ЗУРАГ 3.11 900'001-1100'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ОРЛОГОТой ӨРХИЙН ДУНДАЖ ОРЛОГО, УЛСЫН ДУНДЖААР, 2017 ОН.....	18
ЗУРАГ 4.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, ТӨГРӨГӨӨР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	19
ЗУРАГ 4.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР.....	20
ЗУРАГ 4.3 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА, БҮСЭЭР.....	20
ЗУРАГ 4.4 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, ЗАРЛАГЫН ТӨРЛӨӨР, УЛСЫН ДУНДЖААР.....	21
ЗУРАГ 4.5 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, УЛСЫН ДУНДЖААР..	21
ЗУРАГ 4.6 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГА, ЗАРЛАГЫН ТӨРЛӨӨР, ТӨГРӨГӨӨР, БҮСЭЭР, 2017 ОН.....	22
ЗУРАГ 4.7 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ЗАРЛАГЫН БҮТЭЦ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2017 ОН.....	22
ЗУРАГ 4.8 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ЗАРЛАГААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, УЛСЫН ДУНДЖААР.....	23
ЗУРАГ 4.9 ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МӨНГӨН ЗАРЛАГААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2017 ОН.....	23
ЗУРАГ 4.10 500'001-700'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ЗАРЛАГАТАЙ ӨРХИЙН ДУНДАЖ ЗАРЛАГА,	24
ЗУРАГ 4.11 900'001-1100'000 ТӨГРӨГИЙН МӨНГӨН ЗАРЛАГАТАЙ ӨРХИЙН ДУНДАЖ ЗАРЛАГА, .....	24
ЗУРАГ 5.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР, ТӨГРӨГӨӨР.....	25

ЗУРАГ 5.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН БАЙДЛААР, ХУВИАР.....	26
ЗУРАГ 5.3 АЖИЛТАЙ ХҮНИЙ ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, АЖИЛ ЭРХЭЛДЭГ САЛБАРААР, ТӨГРӨГӨӨР.....	27
ЗУРАГ 6.1 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, ХУВИАР.....	28
ЗУРАГ 6.2 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ, ТӨРЛӨӨР, ТӨГРӨГӨӨР.....	29
ЗУРАГ 7.1 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГО, ТӨГРӨГӨӨР, ӨРХИЙН ТООНЫ ТЭНЦҮҮ 5 БҮЛГЭЭР, 2017 ОН.....	30
ЗУРАГ 7.2 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨРӨЛ, ТӨГРӨГӨӨР, ӨРХИЙН ТООНЫ ТЭНЦҮҮ 5 БҮЛГЭЭР, 2017 ОН.....	30
ЗУРАГ 7.3 НЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ МӨНГӨН ОРЛОГЫН БҮТЭЦ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2017 ОН.....	31
ЗУРАГ 7.4 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, ӨРХИЙН ТООНЫ ТЭНЦҮҮ 10 БҮЛГЭЭР, ХУВИАР, 2017 ОН.....	32
ЗУРАГ 7.5 ӨРХИЙН ХҮНСНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, ХАМГИЙН ЯДУУ БОЛОН ХАМГИЙН ЧИНЭЭЛЭГ БҮЛГЭЭР, ХУВИАР, 2017 ОН.....	32
ЗУРАГ 7.6 ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДЛЫН БҮТЭЦ, СУУРЬШЛААР, ХУВИАР, 2017 ОН.....	33
ЗУРАГ 8.1 НЭГ ӨРХӨД САРД НОГДОХ ДУНДАЖ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ЗАРИМ НЭР ТӨРЛӨӨР, 34	
ЗУРАГ 8.2 НЭГ ӨРХӨД САРД НОГДОХ ДУНДАЖ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ЗАРИМ НЭР ТӨРЛӨӨР, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2017 ОН.....	35
ЗУРАГ 8.3 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, УЛСЫН ДУНДЖААР, 2017 ОН.....	35
ЗУРАГ 8.4 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, 2017 ОН.....	36
ЗУРАГ 8.5 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, БҮСЭЭР, 2017 ОН.....	36
ЗУРАГ 8.6 ХАА-Н БУС ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЭЛДЭГ ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО, ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН НАС, ХҮЙСЭЭР, ТӨГРӨГӨӨР, 2017 ОН.....	37
ЗУРАГ 9.1 ХАДГАЛАМЖТАЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ.....	38
ЗУРАГ 9.2 ӨРХИЙН МӨНГӨН ОРЛОГО БА ХАДГАЛАМЖ, ТӨГРӨГӨӨР.....	38
ЗУРАГ 9.3 ЗЭЭЛТЭЙ ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ.....	39
ЗУРАГ 9.4 ЗЭЭЛИЙН ДАВХЦАЛ, ХУВИАР.....	39
ЗУРАГ 9.5 ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ, СҮҮЛИЙН 12 САРД АВСАН ЗЭЭЛЭЭР, САЯ ТӨГРӨГӨӨР.....	40
ЗУРАГ 9.6 ЗЭЭЛТЭЙ ӨРХИЙН ОРЛОГО, ТӨГРӨГӨӨР.....	40
ЗУРАГ 9.7 ЗЭЭЛИЙН НЭГ САРЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ, МЯНГАН ТӨГРӨГӨӨР.....	41

# I. УДИРТГАЛ

## 1.1 Оршил

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) нь “Өрхийн орлого, зарлагын судалгаа”-г 1966 оноос эхлэн тасралтгүй явуулж ирсэн бөгөөд 1995, 1998, 2002-2003 онуудад “Амьжиргааны түвшний түүвэр судалгаа”-г мөн зохион байгуулж байв.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг улирал тутам явуулах”-аар хуульчилсны дагуу дээрх хоёр судалгааг нэгтгэн тогтмол явуулж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа нь хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын байдлыг тодорхойлохоос гадна өрхийн орлого, зарлагыг тооцох, хэрэглээний үнийн индекс ташигладаг сагс болон жинг шинэчлэх, ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар тооцоход шаардлагатай хэрэглээний мэдээллийг гаргах үндсэн зорилготой улс, бүс, суурьшлын хэмжээнд төлөөлөх чадвартай судалгаа юм.

Уг судалгааны 2017 оны үр дүнг нийтийн хүртээл болгох, мэдээллийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулах зорилгоор 2017 оны 01-р сараас 12-р сарыг дуустал хугацаанд судалгаанд хамрагдсан 11232 өрхийн мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийж, энэхүү танилцуулгыг бэлтгэлээ.

## 1.2 Өрхийн орлого, зарлагыг бүртгэхийн ач холбогдол

ҮСХ-ноос улирал тутам тогтмол явуулдаг “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)”-нд хамрагдах өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонгодог бөгөөд судалгаанд хамрагдсан өрхүүдийн мэдээлэл нь хүн амын амьжиргааг үнэн зөв тодорхойлоход үнэтэй мэдээлэл болдог. Үүнээс гадна судалгаанд хамрагдсан өрхүүд өрхийн орлого, хэрэглээгээ бүртгэж сурснаар дараах ач холбогдолтой юм. Үүнд:

- Өдөр бүрийн тооцоо, төлөвлөлт нь өрхийн эдийн засгийн амжилт болно.
- Өрхийн орлого, зарлагыг тогтмол, сайн бүртгэснээр өрхөд тохиолдох аливаа эрсдэлийг даван туулахад тусална.
- Статистикийн мэдээлэлтэй харьцуулан өөрийн өрхийн орлого, хэрэглээний онцлог, өөрчлөлтийг харж болно.
- Өрхийн орлогоо бодит байдалдаа нийцүүлж зарцуулах, ашиггүй хэрэглээ, үргүй зардлыг багасгах, хуримтлал үүсгэх зэргээр өрхийн эдийн засгийг бэхжүүлэхэд үндсэн материал болж өгдөг.


## II. ӨРХ ХҮН АМЫН ШИНЖ БАЙДАЛ

Энэ бүлэгт 2017 онд судалгаанд хамрагдсан өрх, хүн амын шинж байдлыг судалгаанд хамрагдагсдын хүйс болон насны бүлэг, гэрлэлтийн байдал, ам бүлийн тоо, сууцны төрөл болон тухайн сууцны төрөл дэх орлого, зардлын хэсгийг товч байдлаар танилцуулж байна.

### 2.1 Өрх, хүн амын үндсэн үзүүлэлтүүд


2017 оны судалгааны дүнгээр тооцсон хүн амын нас, хүйсийн суваргаас харахад сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдсэн харагдаж байна. Мөн нийт хүн амын 62.5 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байгаа ба тухайн насны эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь тэнцүү 50 хувь байна.

Зураг 2.1 Хүн амын нас, хүйсийн суварга, хувиар, 2017 он




Нийт хүн амын хүйсийн харьцааг 2016 онтой харьцуулан доорх зурагт харууллаа. Эндээс үзвэл 2017 онд нийт хүн амын 51.8 хувь нь эмэгтэйчүүд, 48.2 хувь нь эрэгтэйчүүд байгаа нь 2016 оны дүнгээс эмэгтэйчүүдийн хувьд 0.1 пунктээр нэмэгдсэн, эрэгтэйчүүдийн хувьд 0.1 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2.2 Хүйсийн харьцаа, хувиар, 2016-2017 он



Судалгааны дүнгээр 2017 онд нийт хүн амын дотор 0-14 насны хүүхэд 31.3 хувийг эзэлж байгаагаас, эрэгтэйчүүдийн 32.8 хувь, эмэгтэйчүүдийн 29.9 хувийг эзэлж байна (Зураг 2.3). 15-49 насны хүн ам нийт хүн амын 51.1 хувийг эзэлж байгаагаас эрэгтэйчүүдийн 51.9 хувь, эмэгтэйчүүдийн 50.3 хувийг, 50-аас дээш насны хүн ам нийт хүн амын 17.9 хувийг эзэлж байгаагаас эрэгтэйчүүдийн 15.6 хувь, эмэгтэйчүүдийн 19.7 хувийг тус тус эзэлж байна.


Зураг 2.3 Хүйсийн харьцаа, насны бүлгээр, 2017 он



18-аас дээш насны хүн амын гэрлэлтийн байдлыг огт гэрлээгүй, гэрлэсэн (батлуулсан, батлуулаагүй), тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн гэсэн 6 бүлэгт хуваан авч үзэхэд сүүлийн жилүүдэд тусгаарласан болон бэлэвсэн хүн амын эзлэх хувь өсөх хандлагатай байна. 2017 оны байдлаар 18-аас дээш насны хүн амын 59.3 хувь нь гэрлэсэн, 27.9 хувь нь огт гэрлээгүй байна. Гэрлэлтээ цуцалсан хүн амын эзлэх хувь 2016 оныхоос 0.2 пунктээр буурсан байна.




Зураг 2.4 Гэрлэлтийн байдал, 2016-2017 он



Өрхийн ам бүлийн бүтцийг Зураг 2.5-д харуулж байна. 2017 оны байдлаар нийт өрхийн 11.8 хувь нь ганц бие өрх байгаа бол 3-4 ам бүлтэй өрхүүд 43.3 хувийг эзэлж байна. 5 ба түүнээс дээш ам бүлтэй өрх нийт өрхийн 27.7 хувийг эзэлж байгаа нь сүүлийн нэг жилийн хугацаанд 2.0 пунктээр нэмэгдсэнийг харуулж байна. Ам бүлийн дундаж тоо 2016 онд 3.5 байсан бол 2017 онд 3.6 болж, өсөх хандлага ажиглагдаж байна.

Зураг 2.5 Ам бүлийн байдал, 2016-2017 он



## 2.2 Өрхийн сууцны нөхцөл

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны мэдээлэл цуглуулалтад орон сууцны төрлийг уламжлалт сууц буюу гэр, орон сууцны байшин, бие даасан тохилог сууц, сууцны тусдаа байшин, оюутан, сурагчдын нийтийн байр, нийтийн зориулалтын бусад байр, зориулалтын бус сууц болон бусад сууц гэсэн 9 сууцны төрлөөр тодорхойлон өрхөөс асуудаг. Энэхүү танилцуулгад сууцны төрлүүдээс хамгийн түгээмэл сууц<sup>1</sup>-ны төрлийг сонгон авч, зарим бага тархалттай хариултуудыг нэгтгэх байдлаар танилцуулж байна. Улсын дунджаар 2017 онд нийт өрхийн 39.1 хувь нь гэрт, 25.5 хувь нь тохилог сууцанд, 33.6 хувь нь байшинд, 1.8 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна.


Зураг 2.6 Сууцны төрөл, өрхийн эзлэх хувиар, 2016-2017 он



Амьдралын хэв маяг, дэд бүтэц зэргээс хамаарч өрхийн амьдарч буй сууцны хэлбэр бүсээр, суурьшлаар харилцан адилгүй байдаг. Тухайлбал Улаанбаатар хотын өрхүүдийн 22.1 хувийг гэрт, 42.6 хувийг тохилог сууцанд, 33.9 хувийг байшинд, 1.4 хувийг бусад сууцанд амьдардаг өрхүүд тус тус эзэлж байна. Харин хөдөө орон нутгийн өрхийн дийлэнх буюу 84.6 хувийг гэрт амьдардаг өрхүүд эзэлдэг бол 1.1 хувийг тохилог сууцанд амьдардаг өрх, 13.7 хувийг байшинд амьдардаг өрх, 0.6 хувийг бусад сууцанд амьдардаг өрх эзэлж байна.

<sup>1</sup> Манай улсын уламжлалт сууц болох гэрийг аль нэг сууцны төрөлтэй нэгтгээгүй буюу гэр, харин орон сууцны байшинг тохилог сууц, байшин гэдэгт сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууцыг хамтатгасан. Бусад сууцны төрөлд оюутан, сурагч, ажилчдын нийтийн байрууд ба зориулалтын бус бусад бүх төрлийн сууцыг оруулсан болно.

Зураг 2.7 Сууцны төрөл, өрхийн эзлэх хувиар, суурьшлаар, 2016-2017 он




Нийт өрхүүдийг бүс дотор нь (Баруун, Хангай, Төв, Зүүн бүсийг авч үзсэн, Улаанбаатар хотыг оруулаагүй) сууцны төрлөөр харьцуулахад гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь Баруун бүсэд (57.3 хувь) хамгийн их, Төвийн бүсэд (46.2 хувь) хамгийн бага байна. Байшинд амьдардаг өрхийн хувьд бүс тус бүрт төдийлөн их ялгаа ажиглагдахгүй байна.

Зураг 2.8 Сууцны төрөл, өрхийн эзлэх хувиар, бүсээр, 2017 он




Өрхийн мөнгөн орлогыг сууцны төрлөөр задлан харахад гэрт амьдардаг өрхийн мөнгөн орлогын 41.2 хувийг цалин хөлсний орлого, 30.1 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 23.5 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 5.2 хувийг бусад орлого эзэлдэг байна. Харин тохилог сууцанд амьдардаг өрхийн мөнгөн орлогын 65.9 хувийг цалин хөлсний орлого, 14.1 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 8.2 хувийг өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 11.8 хувийг бусад орлого эзэлдэг байна. Түүнчлэн 2016 онтой харьцуулахад гэрт амьдардаг өрхийн мөнгөн орлого 2017 онд 641.6 мянган төгрөг болж, 6.7 хувиар, тохилог сууцанд амьдардаг өрхийн мөнгөн орлого 2017 онд 1.4 сая төгрөг болж, 11.2 хувиар, байшинд амьдардаг өрхийн мөнгөн орлого 2017 онд 920.4 мянган төгрөг болж, 4.4 хувиар, бусад сууцанд амьдардаг өрхийн мөнгөн орлого 2017 онд 884.4 мянган төгрөг болж, 9.8 хувиар тус тус өссөн байна. Сууцны аль ч төрөлд цалин хөлсний орлого дийлэнх хувийг эзэлж байгаа бол гэрт болон байшинд амьдардаг өрхийн хувьд өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, тэтгэвэр, тэтгэмжийн орлого мөн өндөр хувийн жинтэй байна.

Зураг 2.9 Өрхийн мөнгөн орлогын бүтэц, сууцны төрлөөр, 2017 он



Өрхийн амьдарч буй сууцны төрөл хэрэглээний зардалд нь хэрхэн нөлөөлж байгааг судлахаар цахилгаан, түлш, орон сууцны төлбөр, тээврийн үйлчилгээ, харилцаа холбооны зардлыг авч үзлээ. Харилцаа холбоо, тээврийн үйлчилгээ, цахилгааны зардал тохилог сууцанд амьдардаг өрхийн хувьд хамгийн их, гэрт амьдардаг өрхийн хувьд хамгийн бага байна. Түлшний зардал байшинд амьдардаг өрхийн хувьд хамгийн өндөр, тохилог сууцны өрхүүдэд хамгийн бага байна.

Зураг 2.10 Зарим хүнсний бус барааны зардал, сууцны төрлөөр, 2017 он



Нэг өрх 2017 оны байдлаар сард дунджаар цахилгааны зардалд 19.6 мянган төгрөг, түлшний зардалд 19.8 мянган төгрөг, орон сууцны төлбөрт 22.5 мянган төгрөг, тээврийн үйлчилгээнд 20.9 мянган төгрөг, харилцаа холбоонд 35.7 мянган төгрөг тус тус зарцуулж байна.

## Ш. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ОРЛОГО

### 3.1 Өрхийн сарын нийт орлого

Нэг өрхийн сарын дундаж орлого улсын дунджаар 2017 онд 1.0 сая төгрөг болж, 2016 оныхоос 91.4 (9.7%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

2017 онд хотод нэг өрхийн сарын дундаж орлого өмнөх оноос 110.8 (11.0%) мянган төгрөг, хөдөөд 69.6 (8.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн орлогыг хооронд нь харьцуулбал, 2017 онд хотын нэг өрхийн сарын дундаж орлого хөдөөгийнхөөс 232.0 (26.2%) мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь өмнөх оноос 41.2 мянган төгрөг буюу 2.8 пунктээр өссөн байна (Зураг 3.1).

Зураг 3.1 Нэг өрхийн сарын дундаж орлого, төгрөгөөр, хот, хөдөөгөөр



Улсын дунджаар нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2017 онд 90.4 хувь болж өмнөх оноос 1.0 пунктээр буурч, бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 5.3 болж 0.7 пункт, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 4.3 болж, 0.3 пунктээр өссөн байна.


Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, нийт орлогод мөнгөн орлогын эзлэх хувь 2017 онд өмнөх оноос хотод 0.8 пункт, хөдөөд 0.5 пунктээр буурч, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.8 пункт, хөдөөд 0.4 пунктээр, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хотод өөрчлөлтгүй, хөдөөд 0.1 пунктээр өссөн байна (Зураг 3.2).

Зураг 3.2 Нэг өрхийн сарын дундаж орлогын бүтэц, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр



Нэг өрхийн сарын дундаж орлогыг бүсээр гарган өмнөх онтой харьцуулбал, 2017 онд Баруун бүсэд 116.9 (13.8%) мянган төгрөг, Хангайн бүсэд 71.9 (9.1%) мянган төгрөг, Төвийн бүсэд 82.3 (8.9%) мянган төгрөг, Улаанбаатар хотод 115.8 (10.8%) мянган төгрөгөөр нэмэгдэж, харин Зүүн бүсэд 3.8 (0.5%) мянган төгрөгөөр буурсан байна (Зураг 3.3).


Зураг 3.3 Нэг өрхийн сарын дундаж орлого, бүсээр



### 3.2 Өрхийн сарын дундаж мөнгөн орлого

Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2017 онд улсын дунджаар 936.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 72.9 (8.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогыг задалвал, цалин хөлсний орлого өмнөх оноос 39.4 (8.2%) мянган төгрөгөөр, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 16.9 (10.2%) мянган төгрөг, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 21.5 (16.4%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 3.4).

Зураг 3.4 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, орлогын төрлөөр, улсын дунджаар



Мөнгөн орлогын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, 2017 онд улсын дунджаар цалин хөлсний орлогын эзлэх хувь 0.1 пункт, бусад орлогын эзлэх хувь 1.3 пунктээр буурч, харин тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь 0.3 пункт, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлогын эзлэх хувь 1.1 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 3.5).

Зураг 3.5 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, улсын дунджаар



Өрхийн мөнгөн орлогыг төрлөөр нь бүсээр задлан харвал цалингийн орлого Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 717.7 мянган төгрөг байгаа бол Зүүн бүсэд хамгийн бага 289.6 мянган төгрөг байна.




Зураг 3.6 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, орлогын төрлөөр, төгрөгөөр, бүсээр, 2017 он




Өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2017 онд хотын өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 61.9 хувийг цалин хөлсний орлого дангаараа бүрдүүлж байгаа бол хөдөөгийн өрхийн хувьд цалин хөлс болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого нийлээд 70.7 хувийг бүрдүүлж байна (Зураг 3.7).

Зураг 3.7 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, хот, хөдөөгөөр, 2017 он




Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн авч үзвэл, улсын дунджаар 300.0 мянган төгрөг хүртэлх орлоготой өрх 2017 онд өмнөх оноос 1.1 пункт, 300.0-500.0 мянган төгрөгийн орлоготой өрх 1.6 пункт, 500.0-700.0 мянган төгрөгийн орлоготой өрх 0.8 пункт, 900.0-1100.0 мянган төгрөгийн орлоготой өрх 0.3 пунктээр буурч, харин 1.1 сая төгрөгөөс дээш орлоготой өрх 3.8 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 3.8).

Зураг 3.8 Өрхийн бүлэглэлт, мөнгөн орлогоор, дүнд эзлэх хувь, улсын дунджаар




Өрхийг мөнгөн орлогоор нь бүлэглэн хот, хөдөөгөөр авч үзвэл, хотын өрхүүдийн 21.2 хувь, хөдөөгийн өрхүүдийн 43.7 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэл орлоготой байхад, хотын 47.0 хувь, хөдөөгийн 23.7 хувь нь 900.0 мянган төгрөгөөс дээш орлоготой өрхүүд байна (Зураг 3.9).

Зураг 3.9 Өрхийн бүлэглэлт, мөнгөн орлогоор, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр, 2017 он




Сард дунджаар 500.0-700.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзвэл, цалин хөлсний орлого 43.8 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 33.3 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 11.4 хувь, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 5.8 хувь, бусад орлого 5.7 хувийг эзэлж байна (Зураг 3.10).

Зураг 3.10 500'001-700'000 төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлого, улсын дундажаар, 2017 он



Мөн сард дундажаар 900.0-1100.0 мянган төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлогын бүтцийг авч үзвэл, цалин хөлсний орлого 58.8 хувь, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 21.2 хувь, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орлого 7.7 хувь, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 7.2 хувь, бусад орлого 5.1 хувийг эзэлж байна (Зураг 3.11).

Зураг 3.11 900'001-1100'000 төгрөгийн мөнгөн орлоготой өрхийн дундаж орлого, улсын дундажаар, 2017 он




## IV. ӨРХИЙН САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА

### 4.1 Өрхийн сарын нийт зарлага

2017 оны дүнгээр өрхийн сарын дундаж зарлага улсын дунджаар 1.1 сая төгрөг болж, 2016 оныхоос 126.2 (13.1%) мянган төгрөгөөр өссөн байна.

Нэг өрхийн сарын дундаж зарлагыг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2017 онд хотод нэг өрхийн сарын дундаж зарлага өмнөх оноос 146.9 (14.6%) мянган төгрөг, хөдөөд 96.7 (10.9%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хот, хөдөөгийн зарлагыг хооронд нь харьцуулбал, 2017 онд хотын нэг өрхийн сарын дундаж зарлага хөдөөгийнхөөс 164.4 (16.7%) мянган төгрөгөөр илүү буюу энэ нь өмнөх оноос 50.1 мянган төгрөг буюу 3.9 пунктээр өссөн байна (Зураг 4.1).


Зураг 4.1 Нэг өрхийн сарын дундаж зарлага, төгрөгөөр, хот, хөдөөгөөр



Улсын дунджаар нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2017 онд 90.9 хувь болж өмнөх оноос 0.7 пунктээр буурч, бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь 5.0 хувь болж 0.5 пункт, өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь 4.1 хувь болж 0.2 пунктээр өссөн байна.


Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, нийт зарлагад мөнгөн зарлагын эзлэх хувь 2017 онд өмнөх оноос хотод 0.6 пункт, хөдөөд 0.1 пунктээр буурч, харин бусдаас үнэгүй авсан хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 0.6 пункт, хөдөөд 0.2 пунктээр нэмэгдсэн байна. Өөрийн аж ахуйгаас үнэгүй хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хотод өөрчлөлтгүй, хөдөөд 0.1 пунктээр буурсан байна (Зураг 4.2).

Зураг 4.2 Нэг өрхийн сарын дундаж зарлагын бүтэц, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр



Бүсээр нэг өрхийн сарын дундаж зарлагыг өмнөх онтой харьцуулбал, 2017 онд Баруун бүсэд 175.6 (18.5%) мянган төгрөг, Хангайн бүсэд 98.8 (11.6%) мянган төгрөг, Төвийн бүсэд 95.0 (9.6%) мянган төгрөг, Зүүн бүсэд 41.8 (5.0%) мянган төгрөг, Улаанбаатар хотод 153.9 (14.9%) мянган төгрөгөөр тус тус нэмэгджээ (Зураг 4.3).


Зураг 4.3 Нэг өрхийн сарын дундаж зарлага, бүсээр



## 4.2 Өрхийн сарын дундаж мөнгөн зарлага


Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага 2017 онд улсын дунджаар 993.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 107.8 (12.2%) мянган төгрөгөөр өссөн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагыг задалбал, хүнсний зүйлийн зарлага өмнөх оноос 14.3 (6.7%) мянган төгрөгөөр, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлага 94.2 (14.5%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна (Зураг 4.4).

Зураг 4.4 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, зарлагын төрлөөр, улсын дунджаар




Мөнгөн зарлагын бүтцийг өмнөх оныхтой харьцуулбал, 2017 онд улсын дунджаар хүнсний зүйлийн зарлагын эзлэх хувь 1.2 пункт, бусдад өгсөн бэлэг, тусламжийн эзлэх хувь 0.3 пунктээр буурч, хүнсний бус бараа, үйлчилгээний болон бусад зарлагын эзлэх хувь 1.5 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 4.5).

Зураг 4.5 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц, улсын дунджаар




Зураг 4.6 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлага, зарлагын төрлөөр, төгрөгөөр, бүсээр, 2017 он




Өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтцийг хот, хөдөөгөөр авч үзвэл, 2017 онд хотын өрх сарын дундаж мөнгөн зарлагынхаа 73.5 хувийг хүнсний бус бараа, үйлчилгээнд, 24.6 хувийг хүнсний зүйлд зарцуулж байгаа бол хөдөөгийн өрхийн хувьд хүнсний бус бараа, үйлчилгээнд 78.3 хувийг, хүнсний зүйлд 18.7 хувийг зарцуулж байна (Зураг 4.7).

Зураг 4.7 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн зарлагын бүтэц, хот, хөдөөгөөр, 2017 он




Өрхийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн авч үзвэл, улсын дунджаар 300.0 мянган төгрөг хүртэлх зарлагатай өрх 2017 онд өмнөх оноос 2.2 пункт, 300.0-500.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 1.8 пункт, 500.0-700.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 0.6 пункт, 700.0-900.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 0.9 пункт, 900.0-1100.0 мянган төгрөгийн зарлагатай өрх 0.3 пунктээр буурч, харин 1.1 сая төгрөгөөс дээш зарлагатай өрх 5.8 пунктээр нэмэгдсэн байна (Зураг 4.8).

Зураг 4.8 Өрхийн бүлэглэлт, мөнгөн зарлагаар, дүнд эзлэх хувь, улсын дунджаар



Өрхийг мөнгөн зарлагаар нь бүлэглэн хот, хөдөөгөөр авч үзвэл, хотын өрхүүдийн 19.3 хувь, хөдөөгийн өрхүүдийн 36.5 хувь нь 500.0 мянган төгрөг хүртэл зарлагатай, харин хотын өрхүүдийн 49.0 хувь, хөдөөгийн 30.9 хувь нь 900.0 мянган төгрөгөөс дээш зарлагатай байна (Зураг 4.9).


Зураг 4.9 Өрхийн бүлэглэлт, мөнгөн зарлагаар, дүнд эзлэх хувь, хот, хөдөөгөөр, 2017 он



Сард дунджаар 500.0-700.0 мянган төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний зүйлийн зарлага 30.7 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 55.2 хувь, бусад зарлага 12.4 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламж 1.7 хувийг эзэлж байна (Зураг 4.10).




Зураг 4.10 500'001-700'000 төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлага, улсын дунджаар, 2017 он



Сард дунджаар 900.0-1100.0 мянган төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлагын бүтцийг авч үзвэл, хүнсний зүйлийн зарлага 25.6 хувь, хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 62.8 хувь, бусад зарлага 9.9 хувь, бусдад өгсөн бэлэг, тусламж 1.7 хувийг эзэлж байна (Зураг 4.11).

Зураг 4.11 900'001-1100'000 төгрөгийн мөнгөн зарлагатай өрхийн дундаж зарлага, улсын дунджаар, 2017 он




## V. ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ БА ЦАЛИН

### 5.1 Өрхийн орлого ба өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлт

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл бол өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлын талаарх үзүүлэлт юм. Өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал өрхийн орлогод хэрхэн нөлөөлж буйг дараах зургаар харуулж байна.

Зураг 5.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар, төгрөгөөр



2017 оны байдлаар өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 1.1 сая төгрөг байгаа нь өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэггүй өрхөөс 53.1 хувиар, өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур байдаг өрхөөс 48.2 хувиар дээгүүр байгаа бөгөөд 2016 оны дүнгээс 9.2 хувиар өсжээ.

2017 оны байдлаар өрхийн тэргүүн нь ажил эрхэлдэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын 62.4 хувь нь цалин хөлсний орлого, 10.1 хувь нь ХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 9.8 хувь нь тэтгэвэр, тэтгэмжийн орлого, 9.3 хувь нь ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого, 8.4 хувь нь бусад орлогоос бүрдэж байна (Зураг 5.2).

Өрхийн тэргүүн нь ажиллах хүчнээс гадуур бол тухайн өрхийн орлогын дийлэнхийг буюу 67.0 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна. 2017 оны байдлаар ажил эрхэлдэггүй өрхийн тэргүүнтэй өрхийн орлогын 36.3 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байгаа нь 2016 оны дүнгээс 18.6 пунктээр нэмэгджээ.

Зураг 5.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхлэлтийн байдлаар, хувиар



Өрхөд байгаа ажилтай хүний тоо 2017 онд дунджаар 1.3 байна. Энэ үзүүлэлт буурсаар ирсэн бөгөөд 2010-2012 онд 1.5, 2014 онд 1.4, 2016 онд 1.3 байжээ.

## 5.2 Ажил эрхлэлт ба цалингийн орлого

Улсын дунджаар 2017 онд нэг өрхөд ноогдох дундаж цалингийн хэмжээ оны үнээр 517.1 мянган төгрөг байна (Хүснэгт 5.1). Энэ нь өмнөх онтой харьцуулахад 8.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 5.1 Өрхийн дундаж цалингийн хэмжээ, өрхийн тэргүүлэгчийн ажил эрхэлдэг салбараар, төгрөгөөр


	Цалингийн дундаж хэмжээ		Цалингийн голч	
	2016	2017	2016	2017
<b>Улсын дундаж</b>	477 742	517 121	350 000	380 000
Ажилтай: Нийт	608 023	655 801	500 000	500 000
Хөдөө аж ахуй	90 891	103 634	-	-
Аж үйлдвэр	831 659	920 788	700 000	800 000
Үйлчилгээ	726 647	804 360	600 000	660 000

Өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн дундаж цалин 655.8 мянган төгрөг байна. Үүнээс хөдөө аж ахуйн салбарт өрхийн тэргүүлэгч нь ажиллаж байгаа өрхийн дундаж цалин хамгийн бага, аж үйлдвэрийн салбарт ажилладаг өрхийн тэргүүнтэй өрхийн дундаж цалин хамгийн өндөр 920.8 мянган төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 10.7 хувиар өсжээ. Цалингийн голч хэмжээ дундаж хэмжээтэйгээ харьцуулахад 103-156 орчим мянган төгрөгөөр бага байгаа нь цалингийн тархалт жигд биш буюу өндөр цалинтай цөөн хүн, бага цалинтай олон хүн нийгэмд байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл 2017 оны байдлаар нийт өрхийн 50 хувь нь 380 мянгаас бага

цалинтай, өрхийн тэргүүлэгч нь ажил эрхэлдэг өрхийн тал хувь нь 500 мянгаас доош цалин авч байна. Аж үйлдвэрийн салбарт энэ ялгаа илүү тод ажиглагдлаа.

Цалингийн хэмжээг зөвхөн ажилтай хүний дунджаар шинжилсэнийг Зураг 5.3-т харуулав. Улсын дунджаар 2017 онд ажилтай нэг хүнд ногдох дундаж цалингийн хэмжээ оны үнээр 391.1 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 6.2 хувиар өсжээ. Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүний цалин хамгийн бага 30.6 мянган төгрөг, аж үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа хүний дундаж цалин хамгийн өндөр, 586.7 мянган төгрөг байна.

Зураг 5.3 Ажилтай хүний цалингийн хэмжээ, ажил эрхэлдэг салбараар, төгрөгөөр




## VI. ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ

### 6.1 Өрхийн хэрэглээний зардал

Өрхийн хэрэглээний зардал нь хоол хүнс, хувцас, байр халаалтын төлбөр болон жижиг зардал зэрэг шууд хэрэглээ болдог, тухайн өрх ахуйн хэрэглээндээ зориулан худалдаж авч буй эд зүйл, үйлчилгээний төлбөр юм. Энэхүү танилцуулгад хэрэглээний зардлыг хүнсний зардал, хүнсний бус зардал, архи согтууруулах ундаа, тамхины зардал гэж хуваан авч үзлээ. Улсын дунджаар 2017 онд өрхийн хэрэглээний зардал сард 859908 төгрөг байгаа бол хотод 937405 төгрөг, хөдөөд 719219 төгрөг байна. Бүсээр хэрэглээний зардлыг авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 993001 төгрөг, Баруун бүсэд 872947 төгрөг, Төвийн бүсэд 774602 төгрөг, Хангайн бүсэд 715947 төгрөг, Зүүн бүсэд хамгийн бага буюу 641976 төгрөг байна. Өрхийн хэрэглээний зардлын бүтцэд дийлэнх хэсгийг буюу 65.2 хувийг хүнсний бус зардал, 33.4 хувийг хүнсний зардал эзэлж байхад согтууруулах ундаа, тамхины зардал 1.4 хувийг эзэлж байна.

Зураг 6.1 Өрхийн хэрэглээний зардлын бүтэц, хувиар



Нэг өрхийн сард хэрэглэдэг хүнсний зарим зардлыг дунджаар тооцож үзвэл 101.1 мянган төгрөгийг мах, махан бүтээгдэхүүнд, 60.9 мянган төгрөгийг гурил, гурилан бүтээгдэхүүнд, 38.8 мянган төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүнд зарцуулдаг байна.

Хүнсний бус зардлыг тооцвол 96.3 мянган төгрөгийг бэлэн хувцасны зардалд, 83.3 мянган төгрөгийг тээврийн үйлчилгээний зардалд, 48.3 мянган төгрөгийг сууц, түрээсийн зардалд, 45.6 мянган төгрөгийг эмнэлгийн үйлчилгээний зардалд, 43.7 мянган төгрөгийг боловсролын зардалд зарцуулжээ (Зураг 6.2).

Зураг 6.2 Өрхийн хэрэглээний зардал, төрлөөр, төгрөгөөр




## VII. ТЭГШ БУС БАЙДАЛ

### 7.1 Орлогын тэгш бус байдал


Мөнгөн орлогыг өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр хувааж үзвэл, хамгийн ядуу хэсгийн мөнгөн орлого улсын дунджаас 3.3 дахин бага, хамгийн чинээлэг хэсгийн мөнгөн орлого 2.2 дахин их байна. Хамгийн чинээлэг хэсгийн сарын дундаж мөнгөн орлого ядуу хэсгээс 7.2 дахин их байна.

Зураг 7.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого, төгрөгөөр, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2017 он



Өрхийн орлого нэмэгдэх тусам орлого өндөртэй бүлгүүдийн хувьд цалингийн орлогын эзлэх хувь өсч байгаа нь ядуу бус өрхийн гишүүдийн ажил эрхлэх боломж ядуу өрхийнхөөс арай илүү байж болохыг харуулж байна. Тодруулбал улсын дунджаар хамгийн чинээлэг бүлэг хамгийн ядуу бүлгийнхнээс 14.1 дахин өндөр цалинтай байна.


Зураг 7.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын төрөл, төгрөгөөр, өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр, 2017 он



Хамгийн ядуу хэсгийн мөнгөн орлогын дийлэнх буюу 49.0 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байгаа бол хамгийн чинээлэг хэсгийн хувьд тэдний сарын

дундаж мөнгөн орлогын 9.8 хувийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого эзэлж байна. Эндээс ядуу өрхийн амьжиргаанд тэтгэвэр, тэтгэмжийн үзүүлэх нөлөө нэлээд их байдаг нь харагдаж байна.

Зураг 7.3 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын бүтэц, дүнд эзлэх хувиар, 2017 он




## 7.2 Өрхийн хэрэглээний зардлын тэгш бус байдал

Өрхийн хэрэглээний зардлыг өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр харвал, хамгийн ядуу хэсгийн хэрэглээний зардал нь хамгийн чинээлэг хэсгийнхээс 2017 онд 6.3 дахин бага байна. Хамгийн ядуу өрхийн хэрэглээний зардлын 45.6 хувь буюу бараг талыг нь хүнсний зардал эзэлж байхад хамгийн чинээлэг хэсгийн хэрэглээний зардлын 73.6 хувийг хүнсний бус зүйлийн зардал эзэлж байна. Зардлын бүтцээс харахад өрхүүд чинээлэг болох тусам хүнсний бус зүйлд зарцуулах хувь, өрхүүд ядуу болох тусам хүнсэндээ зарцуулах зардлын хувь нь өсөж байгаа зүй тогтол харагдаж байна (Зураг 7.4).



Зураг 7.4 Өрхийн хэрэглээний зардлын бүтэц, өрхийн тооны тэнцүү 10 бүлгээр, хувиар, 2017 он




Хамгийн ядуу бүлгийн өрхийн хүнсний зардлын 42.9 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 26.8 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн, 11.3 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүний зардал эзэлж байгаа бол хамгийн чинээлэг өрхийн хүнсний зардлын 28.2 хувийг мах, махан бүтээгдэхүүн, 16.1 хувийг гурил, гурилан бүтээгдэхүүн, 13.0 хувийг сүү, сүүн бүтээгдэхүүний зардал эзэлж байна. Мөн чинээлэг өрхийн зоогийн газар, гадуур хооллосон зардал нийт хүнсний хэрэглээний зардлын 18.0 хувийг эзэлж байхад ядуу өрхийн хувьд 2.2 хувьтай байна.

Зураг 7.5 Өрхийн хүнсний зардлын бүтэц, хамгийн ядуу болон хамгийн чинээлэг бүлгээр, хувиар, 2017 он



Өрхийн хэрэглээний зардлын бүтцийг бүс, суурьшлаар авч үзвэл, хүнсний зардлын эзлэх хувь хөдөөд болон Зүүн бүсэд хамгийн өндөр байна.

Зураг 7.6 Өрхийн хэрэглээний зардлын бүтэц, суурьшлаар, хувиар, 2017 он



## VIII. ӨРХИЙН ОРЛОГОД ҮЗҮҮЛЭХ БУСАД ОРЛОГЫН НӨЛӨӨ

### 8.1 Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өрхийн орлогод үзүүлэх нөлөө

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2017 оны судалгаагаар нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого улсын дунджаар 936.2 мянган төгрөг болж, үүний 182.5 (19.5%) мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн орлого бүрдүүлж байна.

Нэг өрхийн сарын дундаж тэтгэвэр, тэтгэмжийн орлогын өрхийн мөнгөн орлогод үзүүлэх хувь нэмрийг авч үзвэл, 2017 онд өндөр насны тэтгэвэр 122.1 (13.0%) мянган төгрөг, жирэмсний болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 20.5 (2.2%) мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 18.4 (2.0%) мянган төгрөгийг эзэлж байна (Зураг 8.1).

Зураг 8.1 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь, зарим нэр төрлөөр, улсын дунджаар



Нэг өрхийн сарын дундаж тэтгэвэр, тэтгэмжийн орлого 2017 онд өмнөх оноос 16.9 (10.2%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнийг тэтгэвэр, тэтгэмжийн орлогын төрлөөр нь харвал өмнөх оноос хүүхдийн мөнгө 2.1 дахин, бусад тэтгэвэр, тэтгэмжийн орлого 54.6 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамж 32.8 хувь, өндөр настны тэтгэвэр 14.7 хувиар нэмэгдсэн байна.

Тэтгэвэр, тэтгэмжийн орлогыг хот, хөдөөгөөр авч үзвэл, нэг өрхийн сарын дундаж тэтгэвэр, тэтгэмжийн орлого 2017 онд хотод 195.3 мянган төгрөг болж өмнөх оноос 20.0 (11.4%) мянган төгрөгөөр, хөдөөд 159.2 мянган төгрөг болж өмнөх оноос 13.2

(9.1%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Өрхийн сарын дундаж мөнгөн орлогод өндөр настны тэтгэврийн эзлэх хувь хотод 12.6 хувь, хөдөөд 14.1 хувь байна. Нийгмийн даатгал, халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь хөдөөгийн өрхүүдийн амьжиргаанд илүү хувь нэмэр оруулж байна.

Зураг 8.2 Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогод тэтгэвэр, тэтгэмжийн орлогын эзлэх хувь, зарим нэр төрлөөр, хот, хөдөөгөөр, 2017 он



## 8.2 Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний орлого


Өрхийн нийгэм, эдийн засгийн 2017 оны судалгаагаар нийт өрхийн 12.7 хувь нь хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаагаас худалдааны чиглэлээр 39.5 хувь, тээвэрлэлтийн чиглэлээр 22.9 хувь, үйлдвэрлэлийн чиглэлээр 16.0 хувь нь үйл ажиллагаа явуулж байна (Зураг 8.3).

Зураг 8.3 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэлт, үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар, улсын дунджаар, 2017 он




Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн хувьд нэг өрхийн сарын дундаж орлогыг үйл ажиллагааны салбараар авч үзвэл, 2017 оны байдлаар худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого 750.2 мянган төгрөг, барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого 648.7 мянган төгрөг, зочид буудал, ресторан, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг өрхийн сарын дундаж орлого 566.3 мянган төгрөг байна (Зураг 8.4).

Зураг 8.4 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого, үйл ажиллагааны салбараар, 2017 он



Мөн бүсээр авч үзвэл, хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн хувьд өрхийн сарын дундаж орлого Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 696.2 мянган төгрөг, Зүүн бүсэд хамгийн бага буюу 380.5 мянган төгрөг байна (Зураг 8.5).


Зураг 8.5 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого, бүсээр, 2017 он



Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн насаар нь ангилж үзвэл, өрхийн тэргүүлэгч нь 40-49 настай өрхийн сарын дундаж орлого 636.4 мянган төгрөг буюу бусад насны тэргүүлэгчдийг

бодвол хамгийн өндөр, өрхийн тэргүүлэгч нь 30-аас доош, 60-аас дээш настай өрхийн сарын дундаж орлого бусад насны тэргүүлэгчтэй өрхөөс бага байна (Зураг 8.6).

*Зураг 8.6 ХАА-н бус үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхийн сарын дундаж орлого, өрхийн тэргүүлэгчийн нас, хүйсээр, төгрөгөөр, 2017 он*




Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өрхүүдийн сарын дундаж орлогыг өрхийн тэргүүлэгчийн хүйсээр авч үзвэл, эрэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлого эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн сарын дундаж орлогоос 90.5 (18.3%) мянган төгрөгөөр илүү байна (Зураг 8.6).

## IX. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

### 9.1 Хадгаламж


Монгол Улсын нийт өрхийн 21.8 хувь нь 2017 оны байдлаар хадгаламжтай байна. Хадгаламжтай өрхийн хувь 2016 оноос 2017 онд 3 пунктээр буурчээ.

Зураг 9.1 Хадгаламжтай өрхийн эзлэх хувь



Хадгаламжгүй нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлого 2017 онд 817.3 мянга болж, өмнөх оныхоос 75.9 мянган төгрөгөөр, хадгаламжтай өрхийнх 1.4 сая болж өмнөх оныхоос 129.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зураг 9.2 Өрхийн мөнгөн орлого ба хадгаламж, төгрөгөөр



### 9.2 Зээл

Монгол Улсын нийт өрхийн 48.0 хувь нь 2016 онд ямар нэгэн зээлтэй<sup>2</sup> байсан бол 2017 оны байдлаар нийт өрхийн 52.1 хувь нь буюу 461.4 мянган өрх зээлтэй амьдарч байна. Үүнээс: нийт өрхийн 20.8 хувь нь буюу 184.2 мянган өрх цалингийн зээлтэй, 12.4 хувь нь буюу 109.8 мянган өрх тэтгэврийн зээлтэй, 8.2 хувь нь буюу 72.6 мянган өрх малчны зээлтэй, 6.5 хувь нь буюу 57.6 мянган өрх орон сууцны зээлтэй байна.


<sup>2</sup> Өрхийг хэдэн төрлийн зээлтэй байхаас нь үл хамааруулан ямар нэгэн зээлтэй бол тухайн өрхийг зээлтэй өрх гэж тооцсон.

Зураг 9.3 Зээлтэй өрхийн эзлэх хувь



Нэг өрх хэд хэдэн зээлтэй байх тохиолдол нэлээдгүй байна. Тухайлбал, тухайн өрхөд ажил хийдэг хоёр хүн хоёулаа цалингийн зээлтэй байх, тэтгэврийн хоёр ахмад настан хоёулаа тэтгэврийн зээлтэй байх, эсвэл өрхийн нэг гишүүн нь цалингийн зээлтэй байхад нөгөөх нь лизингийн зээлтэй байх гэх мэт олон тохиолдлууд байна. Зээлийн давхцалыг тооцоходоо өрхөд ижил төрлийн зээл олон байгаа тохиолдолд нэг зээл болгон нэгтгэж авсан бөгөөд өөр төрлийн зээл байгаа тохиолдолд давхар зээлтэй гэж үзсэн. Дараах зурагт өрхийн 3 хүртэлх төрлийн зээлийн давхцалыг харууллаа.

Зураг 9.4 Зээлийн давхцал, хувиар



2016 оны байдлаар зээлтэй өрхүүдийн 87.9 хувь нь зөвхөн нэг төрлийн зээлтэй, 10.9 хувь нь 2 төрлийн зээлтэй, 1.2 хувь нь 3 төрлийн давхар зээлтэй байсан бол 2017 онд зээлтэй өрхүүдийн 83.7 хувь нь нэг төрлийн зээлтэй, 14.7 хувь нь 2 төрлийн зээлтэй, 1.6 хувь нь 3 төрлийн зээлтэй байна.

Зээлтэй өрхүүдийн сүүлийн 12 сард авсан зээлийн хэмжээг доорх зурагт харуулж байна. 2017 онд зээлтэй нэг өрх дунджаар 5.4 сая төгрөгийн зээл авчээ. Орон сууцны зээлийн дундаж хэмжээ 42.5 сая төгрөг, автомашины зээлийн дундаж хэмжээ 12.0 сая төгрөг, бизнесийн зээлийн дундаж хэмжээ 10.4 сая төгрөг, цалингийн зээлийн дундаж хэмжээ 5.6 сая төгрөг, өрхийн хэрэглээний зээлийн дундаж хэмжээ 4.0 сая төгрөг,




малчны зээлийн дундаж хэмжээ 3.4 сая төгрөг, тэтгэврийн зээлийн дундаж хэмжээ 3.0 сая төгрөг байна.

Зураг 9.5 Зээлийн хэмжээ, сүүлийн 12 сард авсан зээлээр, сая төгрөгөөр



Зээлтэй өрхийн орлогыг судалж үзвэл 2017 онд зээлтэй нэг өрхийн сарын дундаж орлого 1.1 сая төгрөг болж, 2016 оноос 71.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Орлогын төрлөөр харвал 2017 онд зээлтэй өрхийн цалингийн орлого 600.5 мянга, тэтгэвэр, тэтгэмжийн орлого 183.8 мянга, ХАА-н орлого 89.4 мянга, ХАА-н бус үйлдвэрлэл, үйлчилгээний орлого 82.8 мянга, бусад орлого 100.3 мянган төгрөг байна.

Зураг 9.6 Зээлтэй өрхийн орлого, төгрөгөөр



Зээлийн эргэн төлөлтийг харвал зээлтэй нэг өрх 2017 оны байдлаар сард 453.1 мянган төгрөгийг зээлийн эргэн төлөлтөнд буцаан төлж байна. Орон сууцны зээлтэй өрх уг зээлэндээ сард дунджаар 530.1 мянган төгрөгийг, цалингийн зээлтэй өрх 377.6 мянган төгрөгийг, тэтгэврийн зээлтэй өрх 305.2 мянган төгрөгийг олсон орлогоосоо буцаан төлж байна.

Зураг 9.7 Зээлийн нэг сарын эргэн төлөлт, мянган төгрөгөөр

